

CAPI - Computer Assisted Personal Interview

Таблет компьютерээр мэдээлэл цуглуулах арга



Мэдээлэл цуглуулалтад **CAPI (Computer Assisted Personal Interview)** арга буюу мэргэжлийн судалгааны программ болон Windows үйлдлийн системд суурилсан таблет компьютерээр мэдээллийг цуглуулах аргыг ашигласнаар мэдээлэл цуглуулалтын зардал, хугацааг хэмнэж, үнэн бодитой мэдээллийг цуглуулах боломжийг бүрдүүлж байгаа юм.

CAPI –ийн давуу талууд:

- Таблет компьютер нь Windows үйлдлийн системтэй учир ашиглахад хялбар.
- Зар сурталчилгааны реклам шторк, вэб баннер, лого, сав, баглаа боодол, самбар, сонин, сэтгүүлийн постер зэрэг бүх контентүүдийг тестлэх боломжтой.
- Асуулга хэвлэх зэрэг цаас их зарцуулагддаг байсан нь үгүй болно. Мэдээлэл шивж оруулах операторын ажил үндсэндээ байхгүй болж, ярилцлага авагч нарын үүрэг хариуцлага нэмэгдэнэ.
- Мэдээлэл цуглуулалтын явцад логик шалгалт бүхий мэдээлэл оруулах програмын дагуу ярилцлага явагдснаар алдаагүй мэдээлэл цуглуулах, ярилцлагын хугацааг богиносгох боломжийг бүрдүүлж байна.
- Wireless интернетийн орчин болон 3G интернэтийн орчинд цуглуулсан мэдээллийг тухай бүрт нь төв оффис руу илгээж, мэдээллийг тухай бүрт нь шалгах, засварлах, нэгтгэх, үр дүнг гаргах боломжтой.

- Таблетийг ашиглан ярилцлагын аудио бичлэгийг хийх, респондентийн фото зургийг авч баримтжуулах, үүрэн холбооны сүлжээ нэвтэрсэн ямар ч газарт судлаачийн байршлыг тодруулах зэрэг мэдээлэл цуглуулалтын явцыг хянах, баталгаажуулах боломжтой гэх мэт олон онцлог давуу талуудыг олгож байна.